



**ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Байгууллагын нэр:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Зохион байгуулалтын нэгж:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ

Төлөвлөгөөт үе:

2024 он

Төлөвлөгөө баталсан:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА



/С.НЯМЖАВ/

2024 оныоны дугаар сарын.....өдөр

Төлөвлөгөө боловсруулсан:

ХШДАТ-ын ДАРГА

/А.МЯДАГМАА/

2024 оны 12 оны дугаар сарын 09 өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хувь
1	2	3	4	5	6
Нэг. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт					
"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:					
1.1.1	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; /3.1.1/	Нийтийн мэдээллийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан.	Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна.	Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар мэдээлэл байршуулах болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилон, мэдээллийн хяналтыг цаг тухай бүр тогтмол хийж хэвшсэн. 2024 оны жилийн эцсийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг "shilen.gov.mn"-д хуульд заасан хугацаанд байршуулсан.
1.1.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; /3.1.2/	Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар "Шилэн дансны хууль"-ийн хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны цахим хуудсанд "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу тайлант хугацаанд тусгай

	сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.			зориулалтын мэдээллийг 171 удаа мэдээлэхээс хугацаагаа 171, Газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 182 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 182 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн.
"Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
1.2.1	Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. /3.2.1/	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана.	Илэрсэн төлбөр зөрчлийн 72.6 хувийг барагдуулж ажилласан.	Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.
1.2.2	Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж арга хэрэгжүүлсэн ажлын үр дүнг нэгтгэж дүгнэх, /3.2.2/	Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх,	Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан.	Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах
				32 ажил олгогчийг шалгаж 39 даатгуулагчтай холбоотой 6133.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоон 4293.6 мянган төгрөгийг барагдуулан актын биелэлт 80 хувьтай байна. (2024 оны 12 дугаар сарын 09-ны байдлаар)
				2024 оны жилийн эцсийн байдлаар Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд иргэнээс ирсэн өргөдлийн дагуу Хилийн цэргийн анги, тусгай салбаруудаас ирсэн 1995 оноос хойш ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг нийгмийн даатгалын мэдээллийн сантай тулгалт хийхэд 8 алба хаагчтай

					холоотой 488,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй зөрчил илэрч Улсын байцаагчийн актыг тогтоон төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан.	
1.2.3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг уудирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд зөрчил илрээгүй бөгөөд тайланг хугацаанд НДЁГазрын хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.		ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах		Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг уудирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд зөрчил илрээгүй бөгөөд тайланг хугацаанд НДЁГазрын хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.	
1.2.4	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх /3.2.4/	Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь		Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын нэгдсэн удирдамжийн дагуу их, дунд эрсдэлтэй 15 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөгдсөн. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 онд 4 чиглэлээр хийж 07.3.1 кодтой "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн баримт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хөдөлмөрийн болон иргэнтэй байгуулсан гэрээгүүдийг хамруулан болон шалгаж эрсдэлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг үнэлэн гүйцэтгэсэн.	-2024.02.07-ны өдрийн 13-07/04 дугаартай Хөнгөн хүнс,

				хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Бүрдийн баян бүрд ХХК, Загасан нүд Загастай ХХК, Марал тун далай ХХК, Эрхэм оргил ХХК зэрэг аж ахуй нэгж байгууллагуудын хууль сахин мөрдөлт 70%, эрсдэл үүсэх магадлал 29.2% байна. Эдгээр аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгахад нийт 34 зөрчил илэрч хяналт шалгалтын явцад холбогдох хууль, журмын дагуу заавар зөвлөгөө өгч арилгуулсан. Завхан хишиг хүнс ХХК нь үүсгэн байгуулагдснаас хойш үйл ажиллагаа явуулаагүй, Завхан мах маркет ХХК нь хяналт шалгалтад хамрагдаагүй болно. (эзэн нь гадаадад амьдардаг) -2024.02.07-ны өдрийн 13-07/05 дугаартай Зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа Завхан Азза ТӨХК, Жавхлант хиймөрь хоршоо, Жигд эргэлт ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд 20 зөрчил илэрч, хууль сахин мөрдөлт 76%, эрсдэл үүсэх магадлал 25% байна.Илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн албан шаардлагаар барагдуулж ажилласан. -13-07/06 дугаартай уул
--	--	--	--	--

				уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Түүчээ тэрэг ХХК, ОХД / Вестерн монголиа девелопмент/ ХХК, Форс Голд Майнинг ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт өгөхөд 7 зөрчил илэрч хууль сахин мөрдөлт 80%, эрсдэл үүсэх магадлал 12% байна. Форс Голд Майнинг ХХК 2021 оны 05 сараас үүссэн 38,7 сая төгрөгийн авлагыг НДШ-ийн авлага барагдуулах уулзалтын гэрээ байгуулан харъяа Чингэлтэй дүүргийн НДГ-т шилжүүлсэн. -13-07/10 дугаартай барилга угсралт, завсар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Бэрсүм ХХК, Зуурмаг ХХК, Хан жаргалант стоунс ХХК зэрэг 3 аанб-ын үйл ажиллагааг шалгахад 34 зөрчил илэрснийг шалгалтын явцад арилгуулж, хууль сахин мөрдөлт 50%, эрсдэл үүсэх магадлал 41 % байна. Цаашид илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч зөвлөн туслаж ажилласан. Дээрх чиглэлүүдээр хийсэн ажлын гүйцэтгэлийг хугацаандаа хийж гүйцэтгэн хуваарийн дагуу холбогдох газарт хүргүүлсэн.
--	--	--	--	--

1.2.5	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, /3.2.5/	Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналт, шалгалтын програм"- (http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 доошгүй хувийг шалгаж, зарлуулсан.	Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналт, шалгалтын програм"- (http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна.	"Цахим хяналтын веб програм" хяналтын веб програм" http://10.9.0.5/monitoring-д 2024 оны зөрчилтэй байх магадлалтай мэдээлэл программын шинэчлэлтэй холбоотой 2024 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн байдлаар хянах боломжгүй байна.
1.2.6	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн сангийн тайланг баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төлбөр, барагдуулалт, шалгалтын мөрөөр зохих байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, /3.2.6/	Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохих байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ.	НДЭГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 531,2 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 153,8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 28,9 хувьтай байна. - Дотоодын хяналт шалгалтаар 121,2 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 84,4 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 70,1 хувьтай байна. - Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 7,7 сая төгрөгийн зөрчил илэрч санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 7,7 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 100 хувь.	Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын хурлаар зөвлөлийн холбогдох хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар НДЭГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 531,2 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 306,8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 58.1 хувьтай байна. - Дотоодын хяналт шалгалтаар 104,1 сая төгрөгийн төлбөрөөс 72.8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 70.1 хувьтай байна. (12 дугаар сарын 09-ны байдлаар)
Хоёр. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.					
"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:					
Нийгмийн салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол,	2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн нийгмийн	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нийгмийн даатгалын багц хууль шинээр	НДЭГ-аар ХШГ-аар хяналт шалгалтын жилийн эцсийн тайланд илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн тусган тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

2.1.1	холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.. /4.1.1/,	хийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой шинэчлэн батлагдсан 81 дүрэм, журам болон шийдлэл, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
2.1.2	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.. /4.1.2/	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	2024 оны жилийн эцсийн байлдаар 55 иргэнээс ирүүлсэн өргөдөлд хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн ажилласан. Уг өргөдлүүдийг агуулгаар нь авч үзвэл Тэтгэврийн асуудлаар 8 иргэн Хугацаандаа теледөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлэх асуудлаар 46 иргэн СДД-ын шимтгэл төлөлтийн талаар 1 иргэн

Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх

3.1.1	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах /4.3.1/	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна.	2023 оны байдлаар 275 иргэн даатгуулагчийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтооход оношийн баталгаажилтад хяналт хийж 250 даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоон оношийн баталгаажилт хангалтгүй 25 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоохоос татгалзан буцаасан.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна.	2024 онд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй 254 даатгуулагч, иргэдийн эмчлүүлэгчийн картан дахь лабораторийн болон багажийн шинжилгээ, үзлэг, үечилсэн дүгнэлтийг үндэслэн оношийн баталгаажилтанд хяналт хийж үзэхэд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.
-------	--	--	---	--	---

	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хягас жил тутам тулгалт хийсэн байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хягас жил тутам тулгалт хийдэг байсан бол Халамжийн программ цахим хэлбэрт шилжин мэдээллийг шууд татан авдаг болсонтой холбоотой Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал бүрийн дараа https://app.ndaagol.mn:811/ehmkweb/ программд байршуулан цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийж зөрүүтэй мэдээллийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын офлайн программд засварлан ажилласан.	Эрүүл мэндийн зөвлөлийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Тайлант хугацаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт нийт 41 удаагийн хурлыг зохион байгуулсан. 1986 хүний хөдөлмөрийн чадвар алдлын хувь, хугацааг магадласнаас 236 хүнийг шинээр тогтоож, 1529 хүнийг сунгаж, 220 цуцалсан, 1 хөдөлмөрийн нөхцөл сольсон, 22 шилжиж явсан, 2 шилжиж ирсэн, 108 иргэний хөдөлмөрийн сэдвэр алдлын хувь, оношийн үндэслэл, оношлогоо шинжилгээ хангалтгүй шалтгааны улмаас буцаасан шийдвэр гаргасан. Хөдөлмөрийн чадвар алдлын хувь хугацааг тогтоолгосон 1680 хүн нийгмийн даатгалын сангаас, 1042 хүн нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна. Хувь хэмжээгээр хагас /хэсэгчлэн/ алдсан буюу 50-69 хувиар алдсан 1723, бүрэн буюу 70-100 хувиар алдсан 1002 иргэн байна.
3.1.2	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх /4.3.2/	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх /4.3.2/	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хягас жил тутам тулгалт хийдэг байсан бол Халамжийн программ цахим хэлбэрт шилжин мэдээллийг шууд татан авдаг болсонтой холбоотой Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал бүрийн дараа https://app.ndaagol.mn:811/ehmkweb/ программд байршуулан цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийж зөрүүтэй мэдээллийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын офлайн программд засварлан ажилласан.	Эрүүл мэндийн зөвлөлийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гарган төрөлжсөн мэргэжлийн эмч нартай байгуулсан гэрээний биелэлт, тайлан, бусад гишүүдээс тайланг авч дүнгийн хурлыг зохион байгуулсан. 2024 оны байдлаар мэдээллийн баазын бүрдүүлэлтэд хяналт хийж өвчний төрөл, заалт, оношийн код, овог, нэр, регистрийн дугаар зөрүүтэй

			Говь-алтай, аймгуудын даатгалын дэргэдэх хөдөлмөрийг комисстой Хөдөлмөрийн алдалтын хувь, тогтоолгосон 198 амбулаторийн холбогдох шинжилгээний ижил мэргэжилтний үзлэгийг хийж цахимаар холбогдон хөдөлмөрийн ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, комиссын эмч болон комиссын гишүүдийн ур чадварыг сайжруулан ажилалаа.	Архангай Нийгмийн хэлтсийн Эмнэлэг магадлах хамтран чадвар аппалтын хувь, хогцаа иргэний карт, оношлогоо, материалд мэргэжилтний үзлэгийг хийж цахимаар Эмнэлэг үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, комиссын эмч болон комиссын гишүүдийн ур чадварыг сайжруулан ажилалаа.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ижил мэргэжилтний үзлэгийг Говь-алтай аймагт Говь-алтай, Завхан, Ховд, Увс аймгийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч, төрөлжсөн 3 мэргэжлийн эмч нарыг оролцуулан 2024 оны 09 сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Ижил мэргэжилтний үзлэгт нийт 60 картыг хамруулж Говь-алтай, Завхан, Ховд аймгийн 40 иргэний картыг хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үеийн дүгнэлт болон оношийн баталгаажилтыг хянах шалгуур хуудсаар үнэлж ажиллахад үнэлгээ 89%-тай байна. Энэ арга хэмжээг зохион байгуулсны дүнд ололттой тал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний	байсан нийт 62 тэтгэвэр авагчийн мэдээллийн зөрүүтэй байдлыг оролган ажигласана. Дүнгийн хурал дээр цаашид анхаарч ажиллах асуудлуудыг талаар зөвлөлийн гишүүдтэй санал солилцсон бөгөөд төрийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцдог болонтой холбоотой тэтгэвэр авагчийн мэдээллийг үнэн зөв оруулах нь чухал гэдгийг шинээр томилогдсон нарийн бичгийн даргад анхаарууллаа.
--	--	--	--	---	---	--	---

					санал зөвлөмжийг боловсруулан илэрсэн зөрчил дутагдлыг, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
					Хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн шалтгаанаар судалгааг гарган сумдын засаг дарга болон эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.
					Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд өвчний ангиллаар, бүс нутгийн байдлаар, насны ангиллаар, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр, тэргүүлэх 5 өвчлөлөөр сүүлийн 5 жилээр харьцуулсан судалгааг гарган эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны тайланд тусган орон нутгийн удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт, эрүүл мэндийн магадлалын оролцогч талууд, эмч эмнэлгийн мэргэжилтний сургалтанд танилцуулж ажилласан.
					1. Аймгийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг нийт хүн амд харьцуулсан судалгааг гаргахад 3.8 хувь байна. 47

				хувь нь Нийгмийн халамжийн сангаас, 63 хувь нь Нийгмийн даатгалын сангаас захирагч дутуугийн тэтгэвэр авч байна. 2. Сүүлийн 5 жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоолгосон иргэдийн хувь тогтмол буурсан үзүүлэлттэй байсан. 2019 он – 3697 иргэн 2020 он - 3253 - 444 иргэнээр буюу 12 % 2021 он - 3060 – 193 иргэнээр буюу 5,9% 2022 он – 2887 - 173 иргэнээр - 5,6% 2023 он - 2781 – 106 иргэнээр - 3,6% тус 2024 он – 2725 – 56 иргэнээр 2,0% - тус буурсан байна. 3. Сум тус бүрээр өвчний ангиллаар судалгааг гарган дүнг ЭММЗөвлөлөөр хэлэлцэн сумын удирдлага болон Эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.
				1. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран "Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт цахим сургалтанд Завхан аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 8 гишүүн оролцсон. Тайлант хугацаанд ашиг сонирхлын мэдүүлгээ гарган өгсөн 3 гишүүний мэдээллийг шилэн дансны мэдээлэлд байршуулсан. 2. Эрүүл мэндийн
				Эрүүл мэндийн зөвлөлийн төрөлжсөн магадлалын болон мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна.
				2 удаагийн сургалт зохион байгуулж 12 гишүүн хамрагдсан. Тайлант ЭММТЗ-д хүргүүлсэн.
				Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.
				Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах /4.3.4/
3.1.4				

				магадлалын төв зөвлөлөөс Авилгатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан "Авилгын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт цахим сургалтанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 8 гишүүн оролцсон. 3. 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр АТГ-ын комиссар М.Жамъяачойжил, Р.Төрбулаг нарын зохион байгуулсан "Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдвээр цахим сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, магадлагч эмч нар хамрагдсан. 4. 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Сансарбаярын зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон хяналтын эмч зэрэг 11 хүн хамрагдсан.	
				Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.	
				Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулаагүй.	
				Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилтыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох.	
				Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх /4.1.5/	
3.1.5				Газрын даргыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/12 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан Засгийн газрын 2020 оны 246 тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-д заасны дагуу тус байгууллагын бичиг хэрэг, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан ажилтны 2023 оны баримт бичгийг нэг бүрчлэн цэгцлэн архив нэгж	

					болгон үдэж архивласан. Мөн даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/13 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулан НДЕГ-ын даргын 2019 оны А/194 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" – д заасны дагуу байгууллагын дотоод тохижилтыг нийт ажилтан албан хаагчид хийж гүйцэтгэсэн.
3.1.6	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх /4.1.7/	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	Ажилтан, эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 354 дүгээр тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм болон холбогдох хууль дүрэм, журмыг өдөр тутмын ажил үйлчилгээндээ мөрдлөг болгон ажиллаж байна.	Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг тухай нь бүр өгч ажиллаж байгаа ба нэгжийн ажилтан албан хаагчид авлига, гэмт хэрэгт холбогдоогүй байна.

Дөрөв.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

4."Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хэлтсийн үйл ажиллагаанд санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийх ажлыг зохион байгуулах, тайлагнах", гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.1	Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр ашгийг хуваарилалтад дотоод аудит хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтийн дагуу хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, хэлтсийн даргад танилцуулах, тайлагнах; АТТ-2.1		Нийтийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/86 дугаартай тушаалаар "Нийтийн даатгалын байгууллагын дотоод аудитын журам"-ын 4 дэх заалт нь "Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл"-ийг заасан бөгөөд 4.1.5 дах хэсэгт "Санхүү, төсөв, хөрөнгө нөөцийг зүй зохистой зарцуулж, үр дүнтэй ашиглаж, хамгаалж буй эсэх (2 жил тутамд)"-д хяналт тавихаар журамласан ба НДЭГазрын даргын 2023 онд баталсан удирдамжинд тус хэлтсийн 2017-2022 оны дуусгалх хугацааны сангийн болон үйл ажиллагааны зардалтай холбоотой шалгасан.	Дотоод аудит хийгдэж, үр дүнг тооцож ажилласан байна.	Газрын даргын баталсан удирдамжийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн сангийн 2024 оны 1-10 дугаар сарын хугацаанд олгосон олголтонд шалгалт хийж гүйцэтгэхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг давхардуулан үндэслэлгүй илүү 7 даатгуулагч эхэд 13,1 сая төгрөгийг илүү, нэр бүхий 20 даатгуулагч эхэд 4165,2 мянган төгрөгийг дутуу олгосон бөгөөд НДЭГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" албан бичгийн 3.2-т "...тэтгэмж авах өргөдлийг 2023 онд даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хугацаа нь 2024 он дамжин нийтээр амрах баярын өдөр тохиосон бол тэтгэмж бодох ажлын өдөрт оруулан тооцож дээрх тэтгэмжүүдийг дахин тооцож нөхөн олгоно." гэсний дагуу олгоогүй зөрчил илэрснийг Улсын байцаагчийн акт үйлдэн төлбөр зөрчлийг барагдуулахын Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст даалгаж байна.
4.2	Батлагдсан удирдамжийн дагуу тухайн нэгжийн эрсдэлтэй гэж тооцсон ажил үйлчилгээнд дотоод аудит хийж, ажил сайжруулах санал, дүгнэлт, төлөвлөгөө боловсруулах; АТТ-4.1	Дүгнэлт, тоогоор саналын	Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Нөмрөг сумын ажил үйлчилгээнд дотоод аудит хийж, ажил сайжруулах санал, дүгнэлт гаргах байсан боловч тухайн үеийн цаг агаарын болон автомашины асуудлаас шалтгаалан шалгалтыг хийж	Үр дүнг тооцож ажилласан байна	Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч байх хугацаандаа хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан 16 иргэнтэй холбоотой 21,4 сая төгрөг илүү, 1 иргэнд 1,3 сая төгрөгийн тэтгэмжийг дутуу олгосон зөрчил илэрч Улсын байцаагчийн акт үйлдэн төлбөр зөрчлийг барагдуулан ажиллаж байна.

4.3	Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах; АТТ-4.1	Зохион байгуулсан ажлын тоогоор	Гүйцэтгээгүй болно. 2023 онд ХШДАТастийн хамт олноос болон тастийн даргаас мэргэжил арга зүйн зөвлөгөөг авч байгаа хэлтсийн болон сумдын байцаагч нарт тухай бүр зөвлөгөөг өгч ажилласан. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 139 Улсын байцаагчийн акт үйлдэгдсэн ба акт тус бүрийг тухай бүр нь хянаж ЗГ-ын 2014 оны 354-р тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм"-д заасан нийгмийн даатгалын байцаагчийн үйлдэх баримт бичгийг зөв үйлдэж байгаа эсэх, хуулийн зүйл заалтыг зөв хэрэглэж байгаа эсэх, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэхэд мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.	Өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, арга зүйгээр хангасан байна	ХШДАТастийн хяналт шалгалтын байцаагч болон тастийн даргын зүгээс мэргэжил арга зүйн зөвлөгөөг авч байгаа газрын болон сумдын байцаагч нарт тухай бүр зөвлөгөөг өгч ажилласан. Улсын байцаагчийн үйлдэгдсэн акт тус бүрийг тухай бүр нь хянаж ЗГ-ын 2023 оны 469-р тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм"-д заасан нийгмийн даатгалын байцаагчийн үйлдэх баримт бичгийг зөв үйлдэж байгаа эсэх, хуулийн зүйл заалтыг зөв хэрэглэж байгаа эсэх, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэхэд мэргэжил арга зүйгээр тухай бүр нь ханган ажилласан.	
4.4	Нэгжийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах; АТТ-4.2,	Төлөвлөгөө тайлангийн тоо	Хэлтсийн даргаар нэгжийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн 3 арга хэмжээ 27 ажил үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулсан.	Тухай бүр гарган ажилласан байна.	Газрын даргаар нэгжийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн 4 арга хэмжээ 26 ажил үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулсан.	
4.5	Нэгжийн албан хаагчдын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, дүгнэх, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах; АТТ-4.3	Нэгжийн албан хаагчдын тоогоор	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан	Албан хаагчдын төлөвлөгөөг баталж, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэсэн байна.	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын 2023 оны 301 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан	

4.6	Газрын даргын зөвлөлийн хурал, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах; АТТ-4.4	Үүрэг даалгавар, биелэлтийн тоогоор	“Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ын дагуу түвшинг үнэлэн Үнэлгээний багт гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний хуудсын хамт өгсөн.	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	“Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг аргачлал”-ын дагуу түвшинг үнэлэн Үнэлгээний багт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлгээний хуудсын хамт өгсөн.
4.7	Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллах; АТТ-4.8	Зөрчил гаргаагүй байна.	ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Заавар, стандартыг мөрдөж ажилласан байна.	ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
4.8	Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах; АТТ-4.9	Хуульд заасан хугацаанд архивласан байна.	2022 онд үйлдсэн Улсын байцаагчийн акт, хяналт шалгалтын тайлан, “гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан” хэргийн баримт, гомдлын шаардлагын зөвлөл, тайлан залруулгын баримтыг “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, ХЗДХСайдын 2021 оны А/222 тушаал баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	2023 онд үйлдсэн Улсын байцаагчийн акт 7 боть, НДЕГ-ын шалгалтын баримт 1 боть, дотоодын хяналт шалгалтын тайлан-1, “гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан” хэргийн баримт-1 боть, гомдлын шаардлагын зөвлөл-1 боть баримтыг “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, ХЗДХСайдын 2021 оны А/222 тушаал баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
4.9	Нэгжийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор иргэд, даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцож ажиллах; АТТ-4.13	Судалгаа авсан тоогоор	Тус хэлтсийн нэгдүгээр давхарт байрлах “Киоск” төхөөрөмжинд иргэд даатгуулагч тасалбар аван зөвлөгөө мэдээлэл авсан үнэлгээг авч үзэхэд 42 иргэн нэгжийн албан хаагчдыг үнэлснээс сайн-7, болон маш сайн-28, үнэлгээгүй-7 иргэн үнэлгээ өгсөн байна.	Нэгжийн ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгсөн байна	Тус газрын нэгдүгээр давхарт байрлах “Киоск” төхөөрөмжинд үйлчилгээ авах иргэд даатгуулагч тасалбар аван зөвлөгөө мэдээлэл авсан үнэлгээг авч үзэхэд 27 иргэн нэгжийн албан хаагчдыг 4 иргэн сайн, 23 иргэн маш сайн гэж үнэлгээ тус тус өгсөн байна.

4.10	Нэгжийн Чиг үүрэгтэй холбоотой албан бичиг, тушаал шийдвэрийг төлөвлөх, хянуулах, батлуулах; АТТ-4.15	Албан бичиг, Тушаал шийдвэрийг төлөвлөх, хянуулах, батлуулсан тоогоор	Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, аймгийн Прокурор, Шүүх, Цагдаагийн газар, Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх зэрэг байгууллагуудад нэгжийн болон хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой албан бичгүүдийн төлөвлөн хянуулан албан бичгийг хүргүүлсэн.	Чиг үүрэгтэй холбоотой албан тушаал бичиг, шийдвэрийг төлөвлөж, хянуулж, батлуулсан байна.	Аймгийн Прокурор, Шүүх, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудад нэгжийн болон хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой албан бичгүүдийн төлөвлөн хянуулсан.	
4.11	Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, үр дүнг тооцох; АТТ-4.16		Хөдөлмөрийн тухай хууль болон хэлтсийн дотоод журамд заасны дагуу ажлын цаг ашиглалтанд тухай бүр нь өдөр тутамдаа хяналт тавин ажиллаж байна.	Ажлын цаг ашиглалт сайжирсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалт болон газрын дотоод журмын заалтын дагуу ажлын цаг ашиглалтанд тухай бүр нь өдөр тутамдаа хяналт тавин ажиллаж байна. Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтанд тухай бүр нь хяналт тавьж байна.	
4.12	Цаг үеийн шинж чанартай бусад үйл ажиллагаанд оролцох, хэрэгжилтийг ханган ажиллах. АТТ-4.19	Оролцсон тоогоор	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Улиастай сумын богдын гол багийн Чигэстэй голын урд хэсэгт 2022 онд тарьсан 170 улиас, хайлаас, чацарганы суулгац, 2023 онд 58 чацарганы суулгацыг хамт олны хамтаар тарьж гүйцэтгэсэн. 2023 оны хаврын их цэвэрлэгээ хийх хэлтсийн хуваарьт газар болох малын ченжийн ойр орчим газрын хог хаягдлыг цэвэрлэсэн. Нийгмийн даатгалын хэлтсийн 50 метр хүртэлх эзэмшлийн газар, зам талбайн цэвэрлэгэнд тухай бүр нь оролцсон.	Тухай бүр оролцсон байна.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сард тус газрын ажлын байрны гадна тайлбайд 10 суулгацыг хамт олны хамтаар тарьж гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын хэлтсийн 50 метр хүртэлх эзэмшлийн газар, зам талбайн цэвэрлэгэнд тухай бүр нь оролцсон.	

Тав. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	
1	Арга хэмжээ 1.	Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	3	4	5	7
			-	2-с доошгүй удаа сургалтад хамрагдах	- Удирдлагын академиас зохион байгуулдаг “Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц хамрагдан төгссөн тул Удирдлагын академийн захирлын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/347 дугаартай тушаалаар СЕРТИФИКАТ олгосон. - 2023 оны 10 сард НДЕГ аас зохион байгуулсан 12 цагийн сургалтад хамрагдан “Сургагч багш”-ийн СЕРТИФИКАТ олгосон. - НДЕГ-аас зохион байгуулсан байцаагч ажилтнуудад зориулсан бүх цахим сургалтад бүрэн хамрагдсан. - 2024 оноос шинээр мөрдөж байгаа Нийгмийн даатгалын багц хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар аргачлалын талаар сургалтанд танхим болон цахимаар тухай бүр хамрагдсан.	
2	Арга хэмжээ 2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгээ дээшлүүлэх	-	ТАЗөвлөлөөс зохион байгуулдаг цахим сургалтад хамрагдах, шинээр батлагдсан хууль дүрмийн судлах	- ТАЗ – өөс зохион байгуулдаг 7.4.10 вебинар сургалтад цахимаар тогтмол хамрагдан оролцсон. - “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” сэдэвт сургалтанд танхимаар оролцсон. - Аймгийн прокурорын байгууллагаас зохион байгуулсан “Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулинд орсон нэмэлт өөрчлөлт”-ийн талаарх сургалтанд танхимаар оролцсон.	

Зургаа: Хандлага, ёс зүй, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин
6.1	Арга хэмжээ 1.	Хууль тогтоомж дүрэм журам зааврыг судалж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх.	-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ, Монгол улсын Ёс зүйн хорооний 2024 оны "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг чанд сахин ажиллаж байна. -Тус газрын ёс зүйн дэд хорооны гишүүнээр 2020, 2023, 2024 онуудад сонгогдон ажиллаж байна. -Тайлант онд ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан.
6.2	Арга хэмжээ 2.	Ашиг сонирхлын зөрчилгүй ажласан байна.	Авилга болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхын зэрэгцээ "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-уудыг судлан өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант онд ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд мэдүүлсэн.